БАТЛАВ.
СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГА Б.ЖАРГАЛСАЙХАН

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
2022 ОНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН “НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ” ХӨТӨЛБӨР

| № | Хөтөлбөрийн зорилт | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа |
|---|---|---|
| **НЭГ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ** | | |
| 1.1 | Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, урамшуулах | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын хүрээнд Төсвийн шууд захирагч тасгийн дарга нарын, тасгийн дарга нар төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлана. |
| | | Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг журамд заасны дагуу улирал бүр үнэлнэ. |
| | | Төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээг үндэслэн байгууллагын үнэлгээний баг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын дотоод журмыг баримтлан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар эрх бүхий этгээдэд санал гарган урамшуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх |
| 1.2. | Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, урамшуулах | Төрийн үйлчилгээний ажилтан, албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллана. |
| | | Төрийн үйлчилгээний ажилтан, албан хаагчдын ур чадварын нэмэгдлийг үр дүнгээр тооцож, үнэлгээний дагуу урамшууллыг тогтмол олгоно. |

| | | |
|---|---|---|
| 1.3. | Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах | Байгууллагын шийдвэрээр ажлаас чөлөөлөгдөхгүйгээр сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалт курст хамрагдсан албан хаагчдад суралцсан хугацаанд ажлаа цалгардуулахгүй зохицуулсан тохиолдолд албан тушаалын нь цалин хөлсийг олгож, сурах боломцоогоор хангаж дэмжлэг үзүүлнэ. |
| 1.4. | Хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох | “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдлөг болгон ажиллаж, Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах |
| | | Холбогдох дээд шатны байгууллагаас баталсан бүтэц, орон тоогоор бүтцийг батлуулж мөрдөн ажиллана. |
| | | Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт төрийн жинхэнэ албан хаагчдад албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгуулах саналыг хүргүүлж байна. |
| | | Хүний нөөцийн бодлоготой холбогдолтой асуудлаар гарсан дүрэм журам, зааврыг тухай бүр ажилтан, албан хаагчдад танилцуулах |
| **ХОЁР. НИЙГМИЙН БАТАЛГАА** | | |
| 2.1. | Ажиллах таатай орчинг бүрдүүлэх | Төрийн албан хаагчдын ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлэн өрөө, тасалгаа, танхимыг үе шаттайгаар засч тохижуулна. Үүнд тасалгааны цэцэг тарих, ногоон байгууламж бий болгох |
| | | Ажилтан, албан хаагчдыг ажиллах нөхцөл боломцоогоор хангаж шаардлагатай техник хэрэгслээр ханган ажиллана. |
| 2.2. | Нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх | Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг орон сууц, хашаа байшин худалдан авахад хөнгөлөлттэй зээлд хамруулах, санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэх асуудлыг дүрэм журмын хүрээнд шийдвэрлэнэ. |
| | | Ажилтанд буяны ажилд оролцох чөлөөг ажлын 5 хүртэл өдрөөр тооцож цалинтай чөлөө олгож болно.<br>Ажилтан нас барвал 2 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх, ажилтны төрсөн болон хадам эцэг, эх эхнэр нөхөр хүүхэд нь нас барвал 200000 */Хоёр зуун мянган/* төгрөг, төрсөн ах, эгч, дүү, эмээ, өвөө, ач, зээ |

| | | |
|---|---|---|
| | | нас барвал 100000 /*Нэг зуун мянган*/ төгрөг, нийгмийн даатгалын байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад нас барвал гэр бүлд нь 50000 /*Тавин мянган*/ төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус нэг удаа олгож болно. |
| | | Гэр хороололд амьдардаг ажилтан албан хаагчдад жилд 1 удаа түлээ нүүрсний үнийн дүнгийн хөнгөлөлт олгож дэмжлэг үзүүлнэ. |
| | | Бичиг хэрэг дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн болон архив хариуцсан ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор техник хэрэгслээр хангах, эрүүл аюулгүй орчинд ажиллуулах |
| 2.3. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах | Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагатай хамтран жилд тогтмол 1-ээс доошгүй удаа урьдчилан сэргийлэх үзлэг, нарийн мэргэжлийн оношлогоо шинжилгээнд хамруулах. |
| | | Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчийн биед гэмтэл учирсан тохиолдолд эмчилгээний зардлын тодорхой хувийг хууль дүрэм журамд заасны дагуу олгоно. |
| | | Цасны баяр, явган болон тойрон аялалыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна. Мөн хамт олноороо олон нийтийн ажилд оролцох |
| 2.4. | Чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах | Ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулсан болон хэсэгчлэн хуваан чөлөөт цагаараа хамт олноороо үзвэр үзэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, өдөрлөгийг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах нөхцөлийг бүрдүүлнэ. |
| | | Жил бүрийн 1 дүгээр улиралд ажилтан, албан хаагчдаас ээлжийн амралын хуваарийн саналыг авч, хэлтсийн даргын тушаалаар ээлжийн амралтын хуваарийг батлуулж, ээлжийн амралтын олговрыг тухай бүр олгоно. |

## СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
## 2022 ОНЫ ТӨРИЙН АЛБАН ХААГЧИЙН “НИЙГМИЙН БАТАЛГААГ ХАНГАХ” ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ

| № | Хөтөлбөрийн зорилт | Хэрэгжүүлэх үйл ажиллагаа | Биелэлт |
|---|---|---|---|
| **НЭГ. ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ** | | | |
| 1.1 | Төрийн жинхэнэ албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, урамшуулах | Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын хүрээнд Төсвийн шууд захирагч тасгийн дарга нарын, тасгийн дарга нар төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг батлана. | Давхардсан тоогоор 61 албан хаагч “Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г хэлтэс, нэгжийн төлөвлөгөө, албан тушаалын тодорхойлолттой уялдуулан боловсруулан, нэгжийн даргаар батлуулан, төлөвлөгөний дагуу ажиллаж байна. |
| | | Албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг журамд заасны дагуу улирал бүр үнэлнэ. | ✓ Гүйцэтгэлийн төлөвлөгөөний 01 болон 03 дугаар улирлын биелэлтийг журамд заасан хугацаанд ярилцлагын хэлбэрээр хийж, цаашид анхаарах асуудлыг харилцан ярилцаж, ажилдаа хэрэгжүүлэн ажилладаг.<br>✓ Хагас, жилийн биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 17-ны өдрийн дотор нэгжийн дарга нар дүгнэсэн. |
| | | Төлөвлөгөөний биелэлтийг дүгнэж өгсөн үнэлгээг үндэслэн байгууллагын үнэлгээний баг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн | 2022 оны 03 дугаар улирлын байдлаар давхардсан тоогоор 67 албан хаагчийн үйл ажиллагааны үр дүнг үнэлэн, 22,6 сая төгрөгөөр шагнаж урамшуулсан. |

| | | | |
|---|---|---|---|
| | | акт болон байгууллагын дотоод журмыг баримтлан дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэх талаар эрх бүхий этгээдэд санал гарган урамшуулах арга хэмжээг авч хэрэгжүүлэх | |
| 1.2. | Төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын гүйцэтгэл, үр дүнг үнэлэх, урамшуулах | Төрийн үйлчилгээний ажилтан, албан хаагчтай хөдөлмөрийн гэрээ байгуулж, үр дүнг тооцон ажиллана. | Төрийн үйлчилгээний 29 албан хаагчтай /давхардсан тоогоор/ хөдөлмөрийн гэрээ байгуулан ажиллалаа. Ажлын үр дүнг хагас бүтэн жилээр тайлагнаж, хэлэлцдэг. |
| | | Төрийн үйлчилгээний ажилтан, албан хаагчдын үр чадварын нэмэгдлийг үр дүнгээр тооцож, үнэлгээний дагуу урамшууллыг тогтмол олгоно. | 2022 оны 03 дугаар улирлын байдлаар 6 албан хаагчид 2 удаагийн урамшуулалаар 2,5 сая төгрөгөөр 0000 төгрөгөөр шагнаж урамшуулсан. |
| 1.3. | Ажилтнуудын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх замаар байгууллагын үйл ажиллагааны үр дүнг сайжруулах | Байгууллагын шийдвэрээр ажлаас чөлөөлөгдөхгүйгээр сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалт курст хамрагдсан албан хаагчдад суралцсан хугацаанд ажлаа цалгардуулахгүй зохицуулсан тохиолдолд албан тушаалын нь цалин хөлсийг олгож, сурах бололцоогоор хангаж дэмжлэг үзүүлнэ. | Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн дарга Э.Булганчимэг Удирдлагын академид магистрийн зэргийн сургалтанд, Хүний нөөцийн мэргэжилтэн Н.Наранцацрал Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх дунд хугацааны сургалтанд, Хяналт шалгалтын байцаагч Т. Өнөрсайхан Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх анхан шатны сургалтанд, 3 албан хаагч Төрийн албан хаагчийг мэргэшүүлэх богино хугацааны сургалтуудад тус тус хамрагдан суралцаж байна. Хэлтсийн даргын шийдвэрээр ажлаас чөлөөлөгдөхгүйгээр сурах, мэргэшлээ дээшлүүлэх сургалт курст хамрагдсан албан хаагчдад суралцсан хугацаанд ажлаа цалгардуулахгүй зохицуулсан тохиолдолд албан тушаалын нь цалин хөлсийг олгож, сурах болоцоогоор хангаж дэмжлэг үзүүлж |

| | | | |
|---|---|---|---|
| | | | байна. |
| 1.4. | Хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох | “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийг мөрдлөг болгон ажиллаж, Ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааг тогтмолжуулах | 1. Авлига, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэн ажиллах, нийгмийн даатгалын байцаагчийн ёс зүйг мөрдөн ажиллах хүрээнд Авлигатай тэмцэх газарт сургалтанд хамрагдах хүсэлт гаргасны дагуу хэлтсийн нийт албан хаагчдад 2022 оны 05 дугаар сарын 06-ны өдөр сургалт зохион байгуулав. Сургалтаар Авилгатай тэмцэх газрын соён гэгээрүүлэх хэлтсийн ажилтан Г.Ундармаа “Авилгын ойлголт шалтгаан нөхцөл, хор хөнөөл”, Б.Баяртөгс “Ашиг сонирхолын зөрчил, түүнээс урьдчилан сэргийлэх нь”, Б.Ганхуяг “Авлигын гэмт гэмт хэрэг, анхаарах асуудал”, Ц.Сэлэнгэ “Төрийн албан хаагчийн ёс зүй” сэдвүүдээр мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөв.<br>2. Засгийн газрын 11-11 утас болон НДЕГ-ын утсанд ирж байгаа гомдол мэдээлэлтэй холбоотой асуудлын дор бүр нь судлан танилцаж, байцаагч ажилтнуудад гомдол гаргахгүй ажиллах тал дээр анхаарч ажиллахыг үүрэг болгосон. 11-11 төвөөс нийт -18 гомдол ирснээс 16 гомдлыг шийдвэрлэж ажилласан ба дээрх гомдлууд нь тэтгэмжтэй холбоотой байсан. Хуулийн хугацааны дагуу иргэд даатгуулагчдын тэтгэмжийн мөнгө бодож олгосон ба дээрх гомдлууд нь тус байгууллагын албан хаагчдаас шалтгаалаагүй гомдол болно.<br>3. Нийт албан хаагчдын саналыг үндэслэн хэлтсийн даргын 2022 оны 05 дугаар сарын 09-ний өдрийн А/06 дугаар тушаалаар Ёс зүйн зөвлөлийг шинэчлэн байгуулав. Ёс зүйн зөвлөлийн төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу байцагч ажилтнуудыг ёс зүй, авлига, ашиг сонирхлын |

| | | | |
|---|---|---|---|
| | | | зөрчил гарах эрсдэлээс сэргийлэх зорилгоор соён гэгээрүүлэх сургалтуудад хамруулсан.<br>4. Төрийн албаны зөвлөл, НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөр хамтран хэрэгжүүлж буй "Монгол Улсад маргэжлийн, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлэх нь" төсөл хэрэгжиж байгаа. Энэ төслийн хүрээнд Нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх Ёс зүйн зөвлөлүүдийг идэвхжүүлэх, гишүүдийг чадавхжуулах зорилгоор НДЕГ-ын сургалтын танхимд 2022 оны 4 дүгээр сарын 13-ны өдөр "Үнэт зүйлд суурилсан төрийн албан хаагчийн ёс зүй" сургалт зохион байгуулагдлаа. Сургалтаар үр дүн:<br>✓ Төрийн албаны үнэт үйл, төрийн албан хаагчийн харилцаа хандлага, ёс зүйн манлайлал<br>✓ Төрийн албаны соёл, хамтын ажиллагаанд нөлөөлөх хүчин зүйл<br>✓ Ёс зүйтэй төрийн албыг төлөвшүүлэх, ёс зүн зөрчлөөс урьдчилан сэргийлэх зэрэг ач холбогдолтой.<br>✓ Сургалтанд хэлтсийн дарга, Ёс зүйн зөвлөлийн гишүүд болон шинэ албан хаагчид оролцлоо. |
| | | Холбогдох дээд шатны байгууллагаас баталсан бүтэц, орон тоогоор бүтцийг батлуулж мөрдөн ажиллана. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2018 оны 02 дугаа сарын 28-ны өдрийн А/22 дугаар тушаалаар орон тоог 62 орон тоотойгоор баталсан бөгөөд одоогийн байдлаар 62 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулж байна. |
| | | Төрийн албаны тухай хуулийн 21 дүгээр зүйл, Улсын Их Хурлын 2019 оны 21 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт төрийн жинхэнэ албан хаагчдад албан | Зэрэг дэв олгуулах саналыг Нийслэлийн Нийгмийн даатгалын газарт хүргүүлж, Нийслэлийн Засаг даргын 2022 оны "Зэрэг дэв, түүний нэмэгдэл олгох тухай" А/641 дүгээр захирамжаар 15 албан хаагчдад шинээр зэрэг дэв болон зэрэг дэвийн шатлал |

| | | | |
|---|---|---|---|
| | | тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгуулах саналыг хүргүүлж байна. | ахиулсан. |
| | | Хүний нөөцийн бодлоготой холбогдолтой асуудлаар гарсан дүрэм журам, зааврыг тухай бүр ажилтан, албан хаагчдад танилцуулах | ✓ Шинэчлэн батлагдсан Хөдөлмөрийн тухай хууль болон Төрийн албаны тухай хуульд нийцүүлэн хэлтсийн дотоод журмыг шинэчлэн боловсруулж, хэлтсийн нийт албан хаагчдад төслийг танилцуулан, санал авч нэгтгэн хэлтсийн даргын 2022 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн А/03 дугаар тушаалаар батлуулсан.<br>✓ Засгийн газрын 2022 оны “Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай” 194 дүгээр тогтоолоор "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2019 оны 7 дугаар сарын 3-ны өдрийн 275 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн захиргааны албан тушаалын ангилал, зэрэглэл, түүнд хамаарах албан тушаалын жагсаалт"-ын ТЗ-5 зэрэглэлд “Дүүргийн Засаг даргын дэргэдэх хэлтэс (алба)-ийн мэргэжилтэн" гэж нэмж оруулсны дагуу 20 албан хаагчийн албан тушаалын ангилалд өөрчлөлт оруулж ажиллалаа. |
| **ХОЁР. НИЙГМИЙН БАТАЛГАА** | | | |
| 2.1. | Ажиллах таатай орчинг бүрдүүлэх | Төрийн албан хаагчдын ажиллах таатай орчин нөхцлийг бүрдүүлэн өрөө, тасалгаа, танхимыг үе шаттайгаар засч тохижуулна. Үүнд тасалгааны цэцэг тарих, ногоон байгууламж бий болгох | ✓ Байгууллагын гадна 350м$^2$ талбайг цементлэн, засаж тохижуулав.<br>✓ Хэлтсийн 1, 2 давхарын үйлчилгээний танхимын дотор заслыг хийж гүйцэтгэн, ажилтан албан хаагчдын ажиллах орчныг сайжруулснаар иргэд даатгуулагчид тав тухтай үйлчлүүлэх боломжийг нэмэгдүүллээ. |

| | | | |
|---|---|---|---|
| | | Ажилтан, албан хаагчдыг ажиллах нөхцөл бололцоогоор хангаж шаардлагатай техник хэрэгслээр хангаж ажиллана. | Албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх хүрээнд ажиллах нөхцөл боломжоор хангаж, 20 албан хаагчийн компьютерийг шинэчилсэн. Ингэснээр иргэд, даатгуулагчидад түргэн шуурхай үйлчлэх боломжийг олгосон. |
| 2.2. | Нийгмийн баталгааг хангах, тусламж дэмжлэг үзүүлэх | Тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллаж байгаа албан хаагчдыг орон сууц, хашаа байшин худалдан авахад хөнгөлөлттэй зээлд хамруулах, санхүүгийн дэмжлэг туслалцаа үзүүлэх асуудлыг дүрэм журмын хүрээнд шийдвэрлэнэ. | ✓ Төрийн албаны тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.1, 61.1.5 дахь заалтуудыг үндэслэл болгон шинээр гэр бүл зохиож байгаа 3 албан хаагчдад орон сууцны нөхцөлөө сайжруулахад нь зориулж 1,4 сая төгрөгийн буцалтгүй тусламж үзүүлсэн.<br>✓ Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн дарга Энхтөр овогтой Булганчимэг нь Удирдлагын академид Төрийн удирдлагын чиглэлээр магистрын зэргийн гарагийн сургалтанд хамрагдаж, мэдлэг боловсролоо дээшлүүлж байгааг үнэлэн сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлж 1000000 /нэг сая/ төгрөгийг олгосон.<br>✓ Засгийн газрын 2021 оны 67 дугаар тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 10.3 дахь заалт “10.3.Төв болон орон нутгийн комиссын бүрэлдэхүүнд гурваас дээш жил тасралтгүй, үр бүтээлтэй ажилласан магадлагч эмч, төв комиссын дарга, нарийн бичгийн даргад 3 сарын үндсэн цалинтай нь тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийг ажиллаж байгаа байгууллагаас 3 жил тутамд олгоно.” гэснийг үндэслэн Төв болон орон нутгийн комиссын бүрэлдэхүүнд тасралтгүй, үр бүтээлтэй 3 жил 4 сар ажиллаж байгаа тус хэлтсийн Магадлагч эмч, тэтгэмжийн хяналтын байцаагч Дарьхүүгийн Тэмүүжинд 3 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн мөнгөн тэтгэмж олгосон. |

| | | | |
|---|---|---|---|
| | | | ✓ Өндөр насны тэтгэвэрт гарсан 1 албан хаагчид төрөөс олгодог нэг удаагийн буцалтгүй тусламжид 35,1 сая төгрөгийг олгосон. |
| | | Ажилтанд буяны ажилд оролцох чөлөөг ажлын 5 хүртэл өдрөөр тооцож цалинтай чөлөө олгож болно.<br>Ажилтан нас барвал 2 сарын албан тушаалын үндсэн цалинтай тэнцэх, ажилтны төрсөн болон хадам эцэг, эх эхнэр нөхөр хүүхэд нь нас барвал 200000 /*Хоёр зуун мянган*/ төгрөг, төрсөн ах, эгч, дүү, эмээ, өвөө, ач, зээ нас барвал 100000 /*Нэг зуун мянган*/ төгрөг, нийгмийн даатгалын байгууллагад ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан ахмад нас барвал гэр бүлд нь 50000 /*Тавин мянган*/ төгрөгийн буцалтгүй тусламжийг тус тус нэг удаа олгож болно. | Тус хэлтэс нь 5 ажилтанд буяны ажилд оролцох чөлөөг ажлын 5 хүртэл өдрөөр тооцож цалинтай чөлөө олгож, нийтдээ 1000.000 төгрөгийн мөнгөн тусламж үзүүлээд байна. |
| | | Гэр хороололд амьдардаг ажилтан албан хаагчдад жилд 1 удаа түлээ нүүрсний үнийн дүнгийн хөнгөлөлт олгож дэмжлэг үзүүлнэ. | Төсвийн хэмнэлтийн хүрээнд энэ асуудлыг шийдвэрлээгүй. |
| | | Бичиг хэрэг дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн болон архив хариуцсан ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор техник хэрэгслээр хангах, эрүүл аюулгүй орчинд ажиллуулах | Бичиг хэрэг дотоод асуудал хариуцсан мэргэжилтэн болон архив ажилтны хөдөлмөрийн аюулгүй байдлыг хамгаалах зорилгоор архивын зориулалтын тавиур, нягтруулсан шүүгээ, камер, галын хор, гал унтраах хэрэгсэл, агааржуулагч чийгшүүлэгч, чийг дулаан хэмжигч, зөөврийн шат, компьютер, скайнер, хувилагч, цаас цоологч, хэрчигч, хайч шөвөг зэрэг техник хэрэгслээр хангаж ажиллаж байна. |

| | | | |
|---|---|---|---|
| 2.3. | Албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах | Төрийн албан хаагчдын эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор эрүүл мэндийн байгууллагатай хамтран жилд тогтмол 1-ээс доошгүй удаа урьдчилан сэргийлэх үзлэг, нарийн мэргэжлийн оношлогоо шинжилгээнд хамруулах. | Нийт хүн амыг өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, оношилгоо, шинжилгээнд хамруулах ажлын хүрээнд 25 албан хаагч үзлэг оношлогоонд хамрагдсан. |
| | | Албан үүргээ гүйцэтгэхтэй холбогдуулан төрийн жинхэнэ албан хаагчийн биед гэмтэл учирсан тохиолдолд эмчилгээний зардлын тодорхой хувийг хууль дүрэм журамд заасны дагуу олгоно. | Ажилтан, албан хаагч нар хөдөлмөрлөх үүргээ гүйцэтгэх явцдаа үйлдвэрлэлийн болон бусад хүчин зүйлд өртөж осол гэмтэл гараагүй болно. |
| | | Цасны баяр, явган болон тойрон аялалыг жилд 1-ээс доошгүй удаа зохион байгуулна.<br><br>Мөн хамт олноороо олон нийтийн ажилд оролцох | ”80 жил-8 бүтээлч ажил” аяны хүрээнд нийгмийн хариуцлагаа ухамсарлан, хүрээлэн буй орчин, байгаль эх дэлхийгээ хайрлан хамгаалах, цэвэр цэмцгэр хоггүй хот “Байгаль Эх Дэлхийгээ Хайрлая” уриан дор Нийгмийн даатгалын хэлтсүүд Туул голын сав газрын хогийг цэвэрлэх аянд нэгдэж Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн хамт олон Номин моторсоос Титан төв хүртэлх зам талбай, сав газрын хогийг цэвэрлэлээ. |
| 2.4. | Чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх нөхцөл боломжоор хангах | Ажилтан, албан хаагчдыг бүрэн хамруулсан болон хэсэгчлэн хуваан чөлөөт цагаараа хамт олноороо үзвэр үзэх, биеийн тамирын уралдаан тэмцээн, өдөрлөгийг жилд 2-оос доошгүй удаа зохион байгуулах нөхцөлийг | ➢ Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын нэрэмжит, засаг даргын дэргэдэх хэлтэс, албадын албан хаагчдын дунд зохион байгуулагдсан 6 төрөлт “СПОРТ НААДАМ-2022”-т тус хэлтсийн баг тамирчид амжилттай оролцож, 31 оноогоор ТЭРГҮҮН байранд шалгарч АВАРГЫН ЦОМЫН ЭЗЭД боллоо. |

| | | | |
|---|---|---|---|
| | | бүрдүүлнэ. | ➢ Нийслэлийн Засаг даргын нэрэмжит "Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын спортын IV наадам"-д мөн амжилттай оролцлоо.<br>➢ "Бидний ажил-Миний бахархал" ажил мэргэжлийн уралдааныг Нийгмийн даатгалын байцаагч ажилтнуудын мэдлэг ур чадварыг сорих, дээшлүүлэх, туршлага солилцох, шинэ санал санаачилгыг бүтээлч байдлыг дэмжих, улсын байцаагчийн шалгалтад бэлтгэх, олон нийтэд мэдээллийг хүргэх зорилготойгоор 2022 оны 10 дугаар сарын 21-ний өдөр зохион байгуулагдлаа.<br>Тэмцээнийг НДЕГ-ын Дотоод аудит мониторингийн газрын дарга Б. Ганхуяг , НДЕГ-ын Бодлого хэрэгжилт судалгааны газрын Бодлогын хэрэгжилт хариуцсан ахлах мэргэжилтэн С.Лхагвадорж, ННДГазрын Хяналт шалгалт дотоод аудитын хэлтсийн дарга Л.Очирбал нар шүүн явууллаа. Тэмцээнд хэлтсийн нийт алба хаагчид 5 баг болон хуваагдаж өөрсдийн мэдлэг ур чадвар, авьяас билгээ дайчлан өрсөлдснөөс Тэргүүн байранд: Х.Эрдэнэтуяа даргатай "Ухаалаг зүрх" баг, дэд байранд О.Нямсүрэн даргатай, "Тэгш дүүрэн" баг шалгарлаа. |
| | | Жил бүрийн 1 дүгээр улиралд ажилтан, албан хаагчдаас ээлжийн амралын хуваарийн саналыг авч, хэлтсийн даргын тушаалаар ээлжийн амралтын хуваарийг батлуулж, ээлжийн амралтын олговрыг тухай бүр олгоно. | 2022 оны ээлжийн амралтын хуваарийн саналын албан хаагчдаас авч, хэлтсийн даргын тушаалаар хуваарийг батлуулллаа. Ээлжийн амралттай байгаа, өвчтэй болон чөлөөтэй байгаа ажилтны ажил үүрэг орхигдолгүй байгууллагын үйл ажиллагаа хэвийн үргэлжлэх нөхцлийг хангах ажилласан бөгөөд хэлтсийн бүх ажилтан, албан хаагчид ээлжийн амралтыг бүрэн эдлэж дууссан. |